

“JENESYS” хөтөлбөрт оролцох шалгуур

1. Энгийн хэрэглээний англи эсвэл япон хэлээр харилцан ойлголцох хэмжээний чадвартай байх; (Япон айлд зочлох үедээ орчуулагч дагалдахгүй болно);
2. Бие болон сэтгэцийн хувьд эрүүл, дагалдах хүнгүйгээр Японд нэг долоо хоног орчим зорчих боломжтой байх, хөгжлийн бэрхшээлтэй хүн бол урьдчилан зөвлөлдөх;
3. Гадаадад зорчих паспорттой байх, хэрэв байхгүй бол мэдүүлж авах боломжтой байх;
4. Япон Улсын Засгийн газраас хариуцах зардал (Япон руу ирж, буцах онгоцны тийз, Японд байрлах байр, хоолны зардал болон визийн хураамж)-аас **бусад зардал** (Монгол дахь дотоод тээврийн зардал, паспорт авах хураамж болон хувийн зардал (бэлэг, дурсгалын зүйлс зэрэг)-ийг гаргах боломжтой байх;
5. Багаар ажиллах болон бүх хөтөлбөрт идэвхтэй оролцож, зохион байгуулагчийн зааврыг дагах;
6. Японд нэг долоо хоног орчим аялах талаар гэр бүл, сургуулийн зөвшөөрлийг авсан байх;
7. Хөтөлбөрт хамрагдах хугацаанд болон буцаж ирсний дараа Японы талаарх мэдээллийг бусдад идэвхтэй түгээж, Монголд Японыг сурталчлан таниулахад хувь нэмрээ оруулах чадвартай байх, “JENESYS” хөтөлбөрт оролцогчдын уулзалт зэрэгт идэвхтэй оролцох боломжтой байх;
8. **Уралдаанд шалгарсан ч дээрх болзлыг хангаагүй нь тогтоогдвол “JENESYS” хөтөлбөрт оролцох эрхийг цуцлах тохиолдол бий. Тус эрхийг өөр хүнд шилжүүлэх болон дараа жил рүү хойшлуулах боломжгүй.**